



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 440

Улаанбаатар хот

**Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжүүлсэн “Эрчим хүч төсөл-2”-ийн хүрээнд бий болсон нийт 9,902,804,484.63 (есөн тэрбум есөн зуун хоёр сая найман зуун дөрвөн мянга дөрвөн зуун наян дөрвөн төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн данс бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

*Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт



"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн  
хөрөнгөд бүртгэх, хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүртгэх нийт дүн (төгрөг)
1	1 фаз, ухаалаг PLC тоолуур	2021	ш	42,120	142,662.46	6,008,942,980.39
2	3 фаз, 100А, ухаалаг PLC тоолуур	2021	ш	1,511	276,775.85	418,208,310.28
3	3 фаз, 100А, ухаалаг GSM тоолуур	2021	ш	189	357,243.67	67,519,054.26
4	3 фаз, 5А, ухаалаг PLC тоолуур	2021	ш	805	233,870.29	188,265,579.92
5	3 фаз, 5А, GSM тоолуур	2021	ш	195	314,338.31	61,295,969.72
6	3 фаз, 5А/100V, ухаалаг тоолуур	2021	ш	171	330,421.20	56,502,024.89
7	3 фаз, 5А/100V, ухаалаг GSM тоолуур	2021	ш	9	330,423.26	2,973,809.31
8	Өгөгдөл цуглуулагч	2021	ш	385	1,859,487.20	715,902,570.71
9	AMR програм хангамж	2021	ш	1	410,815,254.46	410,815,254.46
10	MDMS програм хангамж	2021	ш	1	896,962,719.61	896,962,719.61
11	Сервер	2021	ш	2	33,853,252.12	67,706,504.23
12	Сервер	2021	ш	4	29,685,178.81	118,740,715.25
13	Дэлгэц, 16 порт, 8 порт VGA	2021	ш	1	7,338,107.14	7,338,107.14
14	Серверийн кабинет, 42U, 600*800	2021	ш	2	1,639,829.88	3,279,659.76
15	Свич	2021	ш	2	282,353.64	564,707.27
16	Сүлжээний тасдагч	2021	ш	1	154,880.06	154,880.06
17	Кабель шалгагч тестер	2021	ш	1	200,409.23	200,409.23
18	Сүлжээний бахь	2021	ш	1	145,789.45	145,789.45
19	Гүйдлийн трансформатор 50/5	2021	ш	27	63,596.74	1,717,111.93
20	Гүйдлийн трансформатор 75/5	2021	ш	21	63,597.67	1,335,551.06

